

“ЦЭВЭР ХОТ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

/2021-2024 он/

Нэг. Оршил

Манай аймаг нь 327,4 мян.га газар нутагтайгаас 6,1% буюу 20,1 мян.га газар нутгийг төв суурин газар, барилгажсан талбай 1570,4 га газар эзэлдэг.

Аймгийн хүн амын тоо 106,9 мянга байгаагаас Дархан суманд хүн амын 83,5 хувь нь оршин суудаг.

Аймгийн хэмжээнд Сууц өмчлөгчдийн 43 холбоо үйл ажиллагаа явуулж 176 орон сууцны тохижилт, засвар үйлчилгээний ажлуудыг иргэдийн оролцоотой гүйцэтгэж байна.

Дархан, Шарын гол, Орхон, Хонгор сумдад хог хаягдлын төвлөрсөн цэг 8, нийт 36 га талбайг хамарч жилд ойролцоогоор 60,0 мян.тн орчимд хог хаягдал байгальд ил задгай хаягдаж хуримтлагдаад байна. /Байгаль орчны статистикийн мэдээллийн сан/

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.2-т “Хог хаягдлын менежментийг сайжруулах”, 2.5.1.3 “Гэр болон орон сууцны хорооллын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, хот суурин газрын тохижилт, дэд бүтцийг сайжруулах” зэрэг ажлуудыг тусган хэрэгжүүлж байна.

Хоёр. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуульд иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж заасан.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Дархан–Уул аймгийн тогтвортой хөгжилд суурилсан ногоон хөгжлийн хэтийн зорилт, Дархан–Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг эрх зүйн баримт бичигт үндэслэн энэхүү дэд хөтөлбөрийг боловсрууллаа.

2017 онд шинэчлэн батлагдсан Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т “Хог хаягдлын менежментийг сайжруулах орон нутгийн хөтөлбөрийг баталж, биелэлтэд хяналт тавих” эрхийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрхэд заасан.

“Цэвэр хот” дэд хөтөлбөрийн хүрээнд хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлэх, гэр хороолол, орон сууцны гадна тохижилтыг сайжруулах, хотын өнгө үзэмжид сөргөөр нөлөөлсөн гадна зар сурталчилгааны байгууламж, хайс хашааг стандартад нийцүүлэх, иргэдийн амьдрах орчны тав тухыг хангах, эрүүл орчинг бүрдүүлэх ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хотын соёл, тохижилт, хог хаягдлыг бууруулах, хот орчмын байгаль орчныг хамгаалах арга хэмжээг иргэд, байгууллагуудын оролцоотой хэрэгжүүлж, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх нь зүйтэй юм.

Гурав. Зорилго

Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, хот тохижилтыг сайжруулах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг өндөржүүлж, бүх нийтийн оролцоотойгоор цэвэр, эрүүл тав тухтай орчинг бүрдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Дөрөв. Зорилт, арга хэмжээ

Зорилт 1. Хог хаягдлын мэдээллийн санг бий болгох, дахивар нөөц цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулна.

1.1 Хог хаягдлын бүтцийн судалгааг гаргах, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хог хаягдлын бүртгэл хөтлүүлэх

1.2 Энгийн болон аюултай хог хаягдлын мэдээллийн сан үүсгэх

1.3 Хог хаягдлын дахивар нөөц цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх

Зорилт 2. Хог хаягдлын талаархи боловсрол олгох, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгана.

2.1 Хог хаягдлын талаархи боловсрол олгох ажлыг боловсролын бүх шатны байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан иргэдэд сургалт сурталчилгаа явуулах

2.2 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилан ялгах туршилтын төсөл хэрэгжүүлэх, гэр хороолол, орон сууц, албан байгууллагад ангилан ялгах оновчтой хувилбарыг сонгох

Зорилт 3. Хог тээвэрлэгч эрх бүхий байгууллагын менежментийг сайжруулах, хог хаягдлын төвлөрсөн цэгийг сайжруулна.

3.1 Хог тээвэрлэгч эрх бүхий байгууллагын менежментийг сайжруулах, ажилтан албан

хаагчдыг чадавхижуулах

3.2 Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийг сайжруулах, аймгийн төвд нэгдүгээр зэрэглэл, сумдад гуравдугаар зэрэглэлийн хогийн цэг байгуулах

3.3 Аюултай хог хаягдлыг устгах, түр хадгалах зориулалтын байгууламж цэгийг байгуулах

Зорилт 4. Гэр хороолол, орон сууц, нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтыг сайжруулна.

4.1 Гэр хороолол, нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтыг сайжруулах

4.2 Орон сууцны хорооллын тохижилтыг нэмэгдүүлэх

4.3 Хот орчмын байгаль орчныг хамгаалах

Тав. Хэрэгжих хугацаа

Дэд хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

Зургаа. Хамрах хүрээ, нутаг дэвсгэр

Дархан, Хонгор, Шарын гол, Орхон сумдад хэрэгжинэ.

Долоо. Хариуцах байгууллагууд

1. Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар
2. Захирагчийн ажлын алба
3. Нийтийн аж ахуй үйлчилгээний газар
4. Байгаль орчин, аялал жуулчлалын газар
5. Мэргэжлийн хяналтын газар

Найм. Санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санхүүгийн олон талт эх үүсвэрийг ашиглана. Үүнд:

- Улс, орон нутгийн төсөв
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого
- Орон нутгийн хөгжлийн сан
- Гадаад, дотоодын зээл, хандив, тусламж
- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоо
- Бусад эх үүсвэр

Ес. Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

1. Аймгийн хэмжээнд төвлөрсөн 8 хогийн цэгийн 36 га талбайн хог хаягдлыг нэг, гуравдугаар зэрэглэлийн ландфилд байгальд ээлтэй арга технологиор устгасан байна.

2. Сууц өмчлөгчдийн 43 холбооны үйл ажиллагаа нэгдсэн зохион байгуулалтад орж орчны тохижилт, хог хаягдлын асуудлыг шийдвэрлэсэн байна.
3. Иргэд, байгууллагуудын хог хаягдлын талаархи боловсрол дээшилсэн байна.
4. Аюултай хог хаягдлыг түр хадгалах байгууламж байгуулагдсан байна.
5. Хог хаягдлын зохистой менежмент хэрэгжиж, эрүүл ахуйн шаардлага хангасан төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагаа жигдэрч, хог хаягдлын мэдээллийн сан бий болж, хот суурин газрын тохижилт сайжирч **“Цэвэр хот”** болох нөхцөл бүрдсэн байна.

Арав. Хэрэгжилт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан дүгнэж, аймгийн Засаг даргын зөвлөл, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралд тайлагнана.

